



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019
Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.09 № 11
танай _____ -ны № _____ -т

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ИТХ-ЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Төвшрүүлэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв захирагч нь хурлын үйл ажиллагааны зардалд 9478.1 мянган төгрөгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.
2. Сумын иргэдийн Хурлын төлөөлөгчдөд 17300.0 мянган төгрөгийг тэтгэмж урамшууллыг хичээл үйлдвэрлэлийн зардлаас олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, 2018 оны 134 дүгээр тушаалуудыг зөрчсөн бөгөөд аудитын *тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ой тохиосон байна.

003020064

Бусад асуудлын хэсэг

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 97.4 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,432,141.00	1,835,391.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,432,141.00	1,835,391.00
354	Хангамжийн материал	1,432,141.00	1,835,391.00
35410	Бичиг хэргийн материал	392,550.00	314,000.00
35420	Аж ахуйн материал	1,039,591.00	1,521,391.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,905,057.91	2,289,375.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,905,057.91	2,289,375.19
392	Биет хөрөнгө	4,690,057.91	2,134,375.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,858,800.00	2,858,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,429,400.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,894,085.80	8,894,085.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,062,827.89)	(8,189,110.57)
393	Биет бус хөрөнгө	215,000.00	155,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(85,000.00)	(145,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,337,198.91	4,124,766.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,337,198.91	4,124,766.19
51	Засгийн газрын хувь оролцоо	6,337,198.91	4,124,766.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,426,540.00	3,426,540.00
51101	Өмч: - төрийн	3,426,540.00	3,426,540.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,612,397.31	399,964.59
51210	Өмнөх үеийн үр дүн	2,612,397.31	2,612,397.31
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,212,432.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,261.60	298,261.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,337,198.91	4,124,766.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	64,017,700.00	154,729,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,017,700.00	154,729,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,597,700.00	154,729,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,597,700.00	154,729,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	64,621,092.59	156,942,032.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,621,092.59	156,942,032.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,889,700.59	93,463,902.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,146,900.00	45,742,130.00
210101	Үндсэн цалин	47,296,900.00	37,607,955.00
210102	Нэмэгдэл	-	6,555,686.00
210104	Урамшуулал	850,000.00	1,578,489.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,452,308.00	5,716,540.00
210201	Тэтгэврийн даатгал	4,537,560.74	3,978,242.74
210202	Тэтгэмжийн даатгал	479,500.91	434,833.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	383,420.71	347,866.88
210204	Ажилгүйдлийн даатгал	92,823.82	85,929.74
210205	Эрүүл мэндийн даатгал	959,001.82	869,667.04
2104	Хангамж, бараа материалын зардал	3,644,500.00	7,729,600.00
210401	Бичиг хэрэг	633,650.00	1,122,750.00
210402	Тээвэр, шатахуун	2,795,450.00	6,386,850.00
210404	Ном, хэвлэл	215,400.00	220,000.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	441,750.00	2,694,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	441,750.00	2,694,070.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,004,242.59	31,081,562.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	470,500.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,866,100.00	28,265,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	667,642.59	2,615,682.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,731,392.00	63,478,130.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	59,397,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	6,312,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,096,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	21,989,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	531,392.00	4,080,230.00

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	531,392.00	4,080,230.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(603,392.59)	(2,212,432.72)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(603,392.59)	(2,212,432.72)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	64,017,700.00	154,729,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,017,700.00	154,729,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,597,700.00	154,729,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,597,700.00	154,729,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	64,017,700.00	154,729,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,017,700.00	154,729,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,286,308.00	91,251,470.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,146,900.00	45,742,130.00
210101	Үндсэн цалин	47,296,900.00	37,607,955.00
210102	Нэмэгдэл	-	6,555,686.00
210104	Урамшуулал	850,000.00	1,578,489.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,452,308.00	5,716,540.00
210201	Тэтгэврийн даатгал	4,537,560.74	3,978,242.74
210202	Тэтгэмжийн даатгал	479,500.91	434,833.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	383,420.71	347,866.88
210204	Ажилгүйдлийн даатгал	92,823.82	85,929.74
210205	Эрүүл мэндийн даатгал	959,001.82	869,667.04
2104	Хангамж, бараа материалын зардал	2,259,400.00	5,900,000.00
210401	Бичиг хэрэг	644,000.00	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	5,000,000.00
210404	Ном, хэвлэл	215,400.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	3,902,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	3,902,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,627,700.00	29,489,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,707,700.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,920,000.00	29,289,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,731,392.00	63,478,130.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	59,397,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	6,312,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,096,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	21,989,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	531,392.00	4,080,230.00

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	531,392.00	4,080,230.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	(235,195.10)	3,489,606.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	(235,195.10)	3,489,606.50
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,847,592.41	2,847,592.41
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	2,612,397.31	6,337,198.91
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	2,612,397.31	6,337,198.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	2,612,397.31	6,337,198.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,212,432.72)	(2,212,432.72)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	399,964.59	4,124,766.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Харьцуулалт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	154729600.00	150649370.00	4080230.00	97.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154729600.00	150649370.00	4080230.00	97.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95331700.00	91251470.00	4080230.00	95.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47855900.00	45742130.00	2113770.00	95.58
210101	Үндсэн цалин	46855900.00	37607955.00	9247945.00	80.26
210102	Нэмэгдэл	0.00	6555686.00	-6555686.00	-
210104	Урамшуулал	1000000.00	1578489.00	-578489.00	157.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5982000.00	5716540.00	265460.00	95.56
210201	Тэтгэврийн даатгал	4067800.00	3978242.74	89557.26	97.80
210202	Тэтгэмжийн даатгал	478600.00	434833.60	43766.40	90.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	382800.00	347866.88	34933.12	90.87
210204	Ажилгүйдлийн даатгал	95700.00	85929.74	9770.26	89.79
210205	Эрүүл мэндийн даатгал	957100.00	869667.04	87432.96	90.86
2104	Хангамж, бараа материалын зардал	5900000.00	5900000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	700000.00	700000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	5000000.00	5000000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,983,200.00	3,902,970.00	1080230.00	78.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,983,200.00	3,902,970.00	1080230.00	78.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,110,600.00	29,489,830.00	620770.00	97.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	200,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,910,600.00	29,289,830.00	620770.00	97.92

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,397,900.00	59,397,900.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,397,900.00	59,397,900.00	0.00	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,312,200.00	6,312,200.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,096,300.00	31,096,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,989,400.00	21,989,400.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	154,729,600.00	150,649,370.00	4080230.00	97.36
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,729,600.00	150,649,370.00	4080230.00	97.36
132001	Орон нутгийн төсвөөс	154,729,600.00	150,649,370.00	4080230.00	97.36
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, харин залруулагдаагүй нийт 27,048.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 270.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт тогтоож, 26,778.1 мянган төгрөгт 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад томилолтын байр, замын зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 270.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллагын 2022 оны Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 17300.0 мянган төгрөгийг Иргэдийн хурлын төлөөлөгчдөд тэтгэмж урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаал, 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.2.2 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн зардлыг түүвэрлэн анхан шатны баримтаар тулган шалгахад 9478.1 мянган төгрөгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.2.3 Төвшрүүлэх сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээллийг оруулахаас 118 мэдээллийг хугацаанд нь байршуулан 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, 30 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 187,779.6 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн орлого, зарлагын 17 гүйлгээг, төсөв өмч хөрөнгөтэй холбоотой 43 удаагийн 90741.2 мянган төгрөгийн тушаал шийдвэрийн мэдээллийг олон нийтэд ил тод байршуулж мэдээлээгүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээллэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Няравын тайланг анхан шатны баримтанд үндэслэж гаргаагүй, бараа материалын тайланд бүртгэлээр тавих хяналт алдагдсан бөгөөд санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангалтгүй хөтөлж, бараа материалын зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцоогүй, хяналтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна." 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг мөрдөж анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, няравын тайлан мэдээг үнэн зөв гаргаж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төвшрүүлэх сумын ИТХ	4	27,048.1	1	270.0	2	26,778.1	1	0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төвшрүүлэх сумын ИТХ	1	-	-	-	1	-	-	-